

Golomt Capital®

# ДЭЛХИЙН

---

ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО  
ХОНОГИЙН ТОЙМ

2025.08.11

## Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ

### ТОВЧ

- 7-р сард Хятадын экспорт 7.2%-иар өсөж, 322 тэрбум ам.долларт хүрсэн нь шинжээчдийн таамгаас давлаа.
- Хятадын Европ, Зүүн өмнөд Ази, Австрали руу нийлүүлсэн экспорт нэмэгдэж, АНУ руу чиглэсэн экспортын бууралтыг нөхсөн.
- Юанийн ханшийн сулрал экспортын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, Хятадын технологи, e-commerce, logistics секторт сэргэлтийн дохио өгч байна.
- Nasdaq түүхэн дээд түвшинд хаагдаж, Apple-ийн хувьцаа АНУ-д үйлдвэрлэлд \$100 тэрбумын нэмэлт хөрөнгө оруулалт зарласны дараа 13.33%-иар өсөв.
- Холбооны нөөцийн банк 9-р сард хүү бууруулах магадлал ~90% байна.
- Nasdaq-ийн EMA 40 ба EMA 80 нь өсөлтийн трендийг бататгаж, богино хугацааны буцаалтын дараа өсөлт үргэлжлэх төлөвтэй.



### S&P 500 индексийн 2025 оны таамаглал

Deutsche Bank	7,000
Société Générale	6,750
BMO Capital Markets	6,700
Bank of America	6,666
Barclays	6,600
RBC Capital Markets	6,600
Wells Fargo	6,500
Citigroup	6,500
Goldman Sachs	6,500
Morgan Stanley	6,500
JPMorgan Chase	6,500
UBS	6,400
<b>Дундаж</b>	<b>6,678</b>

### Биткойны зорилтот ханш 134,500 ам.доллар.





## АНУ-ын зах зээлийн онцлох мэдээ 2025.08.04-08.08

### NASDAQ ИНДЕКС ТҮҮХЭН ДЭЭД ХАНШАА ШИНЭЧЛЭН ТОГТООЛОО

Өнгөрсөн долоо хоногт АНУ-ын голлох индексүүд өсөлттэй байлаа. Nasdaq индекс хамгийн сайн гүйцэтгэл үзүүлж, түүхэн дээд түвшинд хаагдлаа.

Apple АНУ-д үйлдвэрлэл хөгжүүлэхэд нэмэлт \$100 тэрбумын хөрөнгө оруулалт хийнэ гэж зарласнаар, хувьцаа нь 13.33%-иар өсөж, зах зээлийн өсөлтийг нийтэд нь дэмжлээ.

### АНУ-ЫН ТАРИФ ӨНГӨРСӨН ПҮРЭВ ГАРАГААС ХЭРЭГЖИЖ ЭХЭЛЛЭЭ

АНУ-ын гаалийн шинэ татвар пүрэв гарагт хэрэгжиж эхэлсэн ч зах зээлийн хариу үйлдэл харьцангуй зөөлөн байлаа. Ерөнхийлөгч Трамп Энэтхэгийн бараануудад ОХУ-аас нефть худалдан авж буйг шийтгэл болгож гаалийн татварыг 50%-д хүргэлээ. Харин Швейцаритай хэлэлцээр амжилтгүй болж, импортын татвар 39%-д үлдэв.

### АНУ-ЫН ТӨВ БАНК 9-Р САРД ХҮҮГЭЭ БУУРУУЛАХ МАГАДЛАЛ 90%-ТАЙ

9-р сард хүү бууруулах магадлал өндөр боллоо. Учир нь Холбооны нөөцийн банкны албан тушаалтнууд ойрын саруудад бодлогын хүүг бууруулах магадлалтайг онцоллоо. CME FedWatch-ийн тооцоогоор 9-р сард хүү бууруулах магадлал ~90% байна.



### NASDAQ ИНДЕКСИЙН ХАНШИЙН ТӨЛӨВ

NASDAQ: EMA 40 ба EMA 80 нь хаалтын ханшаас доор байрлаж, хүчтэй өсөх трендийг дэмжиж байна. EMA хоорондын зөрүү тэлж байгаа нь трендийн эрч хүч өндөр хэвээр байгааг илтгэнэ. Өмнөх дээд түвшнийг тестлэж, богино хугацааны буцаалт хийж байж дахин өсөх магадлалтай (healthy pullback).





## Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ 2025.07.28 – 08.03

## БНХАУ-ЫН ХУВЬЦААНЫ ЗАХ ЗЭЭЛ ДОЛОО ХОНОГИЙГ ӨСӨЛТТЭЙ ХААЛАА

Өнгөрсөн долоо хоногт CSI 300 индекс 1.23%-иар, Хонконгийн Hang Seng индекс 1.43%-иар өссөн байна.

Үүнд экспортын эерэг мэдээлэл гол нөлөө үзүүлжээ. 7-р сард Хятадын нийт экспорт өнгөрсөн жилийн мөн үеэс 7.2%-иар өсөж, 322 тэрбум ам.долларт хүрсэн нь шинжээчдийн хүлээлтээс өндөр байлаа. Европ, Зүүн өмнөд Ази, Австрали зэрэг зах зээл рүү нийлүүлэлт нэмэгдэж, АНУ руу чиглэсэн экспортын бууралтыг нөхсөн байна.

АНУ руу хийсэн экспорт 6-р сард 16.1%-иар, 7-р сард 22%-иар тус тус унасан ч, бусад зах зээлд борлуулалт өссөн нь үүнийг тэнцвэржүүлжээ. Мөн 7-р сард юань ам.доллар болон бусад валютын эсрэг суларсан нь экспортын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлсэн гэж таамаглаж байна. Үүнээс шалтгаалж:

- Нэгдүгээрт, Apple, Tesla, Qualcomm зэрэг Хятадад нийлүүлэлтийн сүлжээтэй АНУ-ын технологийн компаниудын хувьцаанд эерэгээр нөлөөлж болзошгүй. Мөн Хятадын e-commerce болон logistics секторт ч сэргэлт бий болж магадгүй (Alibaba, JD, Meituan зэрэг)
- Хоёрдугаарт, Энэ өсөлт түр зуурынх байж болзошгүй (жишээ нь тарифын хугацаанаас өмнө захиалгын хэт өсөлтөөс шалтгаалсан) гэх 2 шалтгаантай байж болно.

Nvidia компанийн H20 чип нь Хятадад өндөр эрэлттэй бөгөөд Baidu, Alibaba, Tencent, DeepSeek зэрэг гол AI хөгжүүлэгчид ашигладаг билээ. Тэгвэл АНУ Хятад руу чипийн экспорт хийхийг хориглоод байсан ч Nvidia, AMD компаниуд Хятадад хийсэн чипийн борлуулалтынхаа 15%-ийг АНУ-ын Засгийн газарт төлөхөөр болсон байна. Тэгэхээр Хятад руу нийлүүлэгдэх чипний борлуулалт нэмэгдэхээр боллоо.

Golomt\_Capital created with TradingView.com, Aug 11, 2025 12:06 UTC+8

Hang Seng Index - 1W - HSI O24,946.55 H24,969.30 L24,775.73 C24,906.90 +48.08 (+0.19%) +48.08 (-0.19%)  
Vol: The data vendor doesn't provide volume data for this symbol.



**Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд**

Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open
Berkshire Hathaway Inc.	Palantir	Pfizer	AMD	Uber	APPLOVIN	D:WAVE	theTradeDesk	fuboTV
wayfair	hims   hers	CATERPILLAR	SUPERMICR	shopify	IONQ	CELSIUS	ROKET LAB	TEMPUS
BIONTECH	mercado libre	Lemonade	ARISTA	OSCAR	duolingo	Lilly	SoundHound	TERAWULF
onsemi	AXON	bp	Opendoor	novo nordisk	symbotic	ConocoPhillips	NUSCALE	FET
ILMCO	Navitas	DUKE ENERGY	Snap Inc.	Walt Disney	FORTINET	HUT 8	KRATOS	Wendys
freshpet	VERTEX	Marriott INTERNATIONAL	AsteraLabs	Six Flags Entertainment Corporation	elf	VISTRA ENERGY	BLOCK	CANOPY GROWTH
axsome	bellring	ESPERION	Upstart	geron	ENERGY TRANSFER	SONY	A ATLISSIAN	CALUMET
TG Therapeutics	BWXT	EATON	Lucid	dave	DRAFT KINGS	Establishment Labs	twilio	YULCHA1
Tyson	LATTICE	Recursion	RIVIAN	GEO	Dutch Bros	PELOTON	T2	docebo
IDEXX LABORATORIES	THREDUP	DUPONT	Clover	McDonald's	Jack in the box	Brookfield	Pinterest	Algonquin

http://eps.sh/cal © 2025 Earnings Whispers

**Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд**

Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open
monday.com	BIGBEAR.AI	CIRCLE	CoreWeave	Arcos Dorados	CISCO	FIRST MAJESTIC	APPLIED MATERIALS	Flowers Foods
BARRICK	OKLO	sea	rigetti	Brinker INTERNATIONAL	EQUINOX GOLD	JD.COM	NU	BitFuFu
village farms	AMC	on	CAVA	Elbit Systems	d-local	JOHN DEERE	KULR	Volition
Franco-Nevada	AST SpaceMobile	pony	GRAIL	INNOVIZ TECHNOLOGIES	AVINO	amcor	the metals company	
EXCELERATE ENERGY	ARCHER	KOPIN	ZEVRA THERAPEUTICS	ARS PHARMA	Red Robin	Canaan	SANDISK	
AADN	microvast	Liquidia	DiaMedica THERAPEUTICS	MAREX	SurgePays	Advance! Auto Parts	Globant	
LINCOLN TECH	PLUG	CardinalHealth	HBR BLOCK	stratasys	electrovaya	NICE	gambling.com	
WW	Pennant Park Investment Corporation	Autolus	HYLIION	ASHS	alvotech	NetEase Games	STRATTEC	
LEGEND BIOTECH	GoPro	Paysafe	REKOR	PERSPECTIVE BIOPHARMACEUTICALS	StandardAero	BIRKENSTOCK	PIONEER POWER SOLUTIONS	
DIVERSIFIED energy	FLUENCE	TENCENT MUSIC ENTERTAINMENT	SURFAIR MOBILITY	CAE	Biofrontera	Cellebrite	darebio	

http://eps.sh/cal © 2025 Earnings Whispers